



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 8/05

Жаргалтхаан сум

### Хариуцлагтай жижүүр томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9, Байгууллагын дотоод журмын 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Бүх нийтийн амралтын өдрүүд буюу 2025 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс 2025 оны 03 сарын 05 ны хүртэл цагаан сарын баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулах хуваарийг нэгдүгээр, хариуцлагатай жижүүр, эргүүлээр ажиллах хугацаанд дагаж мөрдөх ажлын зааварчилгааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
- Хуваарийн дагуу жижүүрийн үүрэг гүйцэтгэхдээ гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай эргүүл, жижүүрүүдэд үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг арга зүйч (Т.Энхнаран)-д даалгасугай.

Хавсралт: 2 хуудастай.

ЭРХЛЭГЧ



Д.ӨНӨРЖАРГАЛ